

**ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗАР, НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ӨРГӨДӨЛ ГОМДОЛ  
ШИЙДВЭРЛЭЛТИЙН 2019 ОНЫ ТАЙЛАН**

2020.01.03

Улиастай


Завхан аймгийн Засаг дарга, түүний Тамгын газарт болон сум байгууллагуудад ирсэн өргөдөл, гомдлыг "Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай" Монгол улсын хууль, "Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоолын дагуу иргэдээс мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаар болон амаар, бичгээр ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэн төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг аль болох хүртээмжтэй, шуурхай, чирэгдэлгүй хүргэх боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.

Аймгийн Засаг дарга, Засаг даргын орлогч, Тамгын газрын дарга нар хуваарийн дагуу иргэдтэй биечлэн уулзаж, өргөдөл, гомдлыг амаар болон бичгээр хүлээн авч шийдвэрлэн хариуг өгч, бусад өдрүүдэд хэлтсийн дарга нар иргэдийг хүлээн авч уулзаж өргөдөл гомдлыг шийдвэрлэн ажиллаж байна.

Иргэдээс аймгийн Засаг дарга болон түүний Тамгын газарт 2019 онд бичгээр 183 өргөдөл ирүүлснээс 175 өргөдлийг шийдвэрлүүлж 8 өргөдөл шийдвэрлэх хугацаа нь хүлээгдэж шийдвэрлэлт 95.6 хувьтай байна.



Цахимаар буюу Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах төвөөр уламжлан 10, аймгийн Засаг даргын иргэдээ сонсох 70461212 утсанд 160 иргэн хандсан байна.



Нутгийн захиргааны байгууллагуудад иргэдээс 3748 өргөдөл гомдлыг хүлээн авч 3607 өргөдлийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэн хариу өгч, 57 өргөдлийг бусад байгууллагад шилжүүлж, 1 өргөдөл хугацаа хэтрүүлэн шийдвэрлэж, 83 өргөдөл хугацаа болоогүй хүлээгдэж байна. Нутгийн захиргааны байгууллагад иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлт 97,8 хувьтай байна.

Өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэхдээ тухай бүр дүгнэлт хийж, хяналт шинжилгээ үнэлгээг хийж биелэлтийг тооцон ажиллаж байна.

### Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл гомдлын тоо	Шийдвэрлэлт				Шийдвэрлэлт хувь
			Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн	Хугацаа болоогүй	
1	Завхан аймгийн Засаг даргын Тамгын газар	353	300	35		18	94.9%
2	Нутгийн захиргааны байгууллага	3748	3607	57	1	83	97.8%
<b>2019 оны дүн</b>		<b>4101</b>	<b>3907</b>	<b>92</b>	<b>1</b>	<b>101</b>	<b>97.5%</b>

**Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлт/хэлбэрээр/**

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдол, санал хүсэлт	Үүнээс:					
			Бичгээр	ЗГИОНХ төвөөр	Цахим хэлбэрээ	Утсаар хандсан	Биечлэн уулзсан	Бусад
1	Завхан аймгийн Засаг даргын Тамгын газар	353	183	10	-	160	-	-
2	Нутгийн захиргааны байгууллага	3748	3510	3	9	77	132	17
<b>2019 оны дүн</b>		<b>4101</b>	<b>4101</b>	<b>3693</b>	<b>13</b>	<b>9</b>	<b>237</b>	<b>132</b>

**Өргөдөл, гомдол, санал хүсэлтийн агуулга**

№	Аймгийн нэр	Зонхилж байгаа асуудал /тоо, нийт өргөдөл, гомдолд эзлэх хувь/
1	Завхан аймаг	<p>Нийт <b>4101</b> өргөдлөөс Хүсэлт 3157 /77%                      Санал 861 /21%                      Гомдол 82 /2%</p> <p>1. Монгол улсын Засгийн газраас 2019 оныг “Иргэн төвтэй төрийн үйчилгээний жил” болгон зарласан тогтоолыг хэрэгжүүлж аймгийн Засаг даргын “Ард иргэдээ сонсох VII аян”-ны хүрээнд “Төрийн үйлчилгээг багт” арга хэмжээг 2019 оны 08, 10 дугаар саруудад 23 сумын хөдөөгийн 110 багт зохион байгуулсан.</p> <p>2. Хэлтэс, агентлаг, албан байгууллагын удирдах ажилтнуудыг хамруулан зохион байгуулдаг “Шуурхай хурал”-аар иргэдээ сонсох 70461212 утсанд хандсан асуудлыг шийдвэрлэн ажиллаж байна.</p> <p>3. 2020 оны дүгээр сарын эхний хоногос “Ард иргэдээ сонсох VIII аян”- эхлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.</p>

**ТАНИЛЦАЖ ХЯНАСАН:**

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН

ГАЗРЫН ДАРГА

Л.ЛХАМСҮРЭН

**ТАЙЛАНГ НЭГТГЭЖ БОЛОВСРУУЛСАН:**

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН

ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Н.ЯДАМЦОО